2019 МОНГОЛБАНК

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН



Монгол Банк

Ерөнхийлөгч
Н.БАЯРТСАЙХАН

Бид урагшаа харж, улс орны эрх ашгийг эрхэмлэж, дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахын төлөө, бодлого шийдвэрээ гарган хэрэгжүүлж байна.

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч
О.ЭРДЭМБИЛЭГ

Монголбанк хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эрүүл банкны салбартай болохын төлөө ажиллаж байна. Цаашид эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгохын тулд санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, макро бодлогын уялдааг хангах, эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох нь чухал байна.

Дэд Ерөнхийлөгч
Б.ЛХАГВАСҮРЭН

Эдийн засгийн сэргэлтийг дагаад зээл өсч байгаа ч дийлэнх хувь нь хэрэглээний зээлд төвлөрч байгаа тул Монголбанкны Мөнгөний бодлогын хороо макро зохистой бодлогын хүрээнд тодорхой шийдвэрүүдийг гаргаж, зохицуулалтуудыг хийсэн.

МОНГОЛБАНКНЫ 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН

1 МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО ИНФЛЯЦИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАЖ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИВ

2 “БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР”-ИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭВ

3 МОНГОЛБАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ 1.2 ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР ӨСЧ, АУДИТААР БАТАЛГААЖИВ

4 ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ 4.0 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЧ ӨСЛӨӨ

5 ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ ҮР ДҮНД ХҮРЧ ЭХЛЭВ

МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК

ОУВС-ИЙН АЖЛЫН ХЭСЭГ ДҮРМИЙН IV ЗААЛТЫН 2019 ОНЫ ЗӨВЛӨЛДӨХ ЯРИА ХЭЛЭЛЦЭЭГ ХИЙЛЭЭ 10

МОНГОЛ УЛСАД БАНК САНХҮҮГИЙН САЛБАР ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 95 ЖИЛИЙН ОЙГ ӨРГӨН ХҮРЭЭНД ТЭМДЭГЛЭВ 11

“ЭХ ОРНЫХОО АЛТЫГ ЭРДЭНЭСИЙН САНДАА” АЯНЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ 12

“ХАРИУЦЛАГАТАЙ ХАРИЛЦАГЧ – ХАРИУЦЛАГАТАЙ БАНК” АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ 13

МӨНГӨН ДЭВСГЭРТИЙН ХАМГААЛАЛТЫН ЭЛЕМЕНТҮҮДИЙГ САЙЖРУУЛЖ, НӨӨЦ ДАХИН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА 14

6
МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН “ШИЛДЭГ ТҮНШЛЭЛ–2019” ШАГНАЛ ХҮРТЛЭЭ

7
ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ТОМООХОН АХИЦ ГАРЛАА

8
МОНГОЛБАНК УИХ–ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

9
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГАНЫГ “САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” СЭДВИЙН ДОР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК МОНГОЛБАНК

БАНКУУДЫН ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРИЙГ МАГАДЛАН ШАЛГАХААР БОЛОВ
15

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ЭДИЙН ЗАСАГ, БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭВ
16

МОНГОЛ УЛС МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ
17

ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ ТОМООХОН АЛХМУУДЫГ ХИЙЛЭЭ
18

МОНГОЛБАНК ОУВС–ГААС БОЛОВСРУУЛАН ГАРГАСАН СТАТИСТИКИЙН “МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТЫН ТУСГАЙ СТАНДАРТ”–ЫГ НЭВТРҮҮЛЭВ
19

1 МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО ИНФЛЯЦИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАЖ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИВ

Монголбанк Засгийн газартай хамтран "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр" болон Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сүүлийн хугацаанд Монгол Улсын эдийн засагт томоохон ахиц гарлаа. Тухайлбал, Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа бодлого нь инфляцийг Төв банкны зорилт буюу 8% орчимд тогтворжуулж, эдийн засгийн өсөлтийг дэмжив. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт сүүлийн үед тогтмол өсч, 2019 оны 1-р улиралд 8.6%-д хүрлээ.

Бодлогын хүү 2017 оноос хойш буурч өдгөө 11%-д байгаа нь зээлийн өсөлтийг хангах хэмжээнд буюу санхүүгийн болон бодит секторoор дамжиж эдийн засгийг дэмжих чиглэлд байна. Төв банкнаас гаргаж буй шийдвэрүүд нь инфляцийг дунд хугацаанд тогтворжуулах зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн өсөлт, идэвхжил, ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх юм.



Инфляци 2019 оны 2-р хагаст өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлөв:

- Нийлүүлэлтийн хомсдлоос шалтгаалж махны үнэ өссөнөөр инфляцид үзүүлэх нөлөө нэмэгдэж 2.96%-д хүрлээ.
- Шатахууны хилийн үнэ газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнийн савлагааг даган өөрчлөгдөж байгаагаас дотоодын шатахууны үнэ 4, 5 дугаар сард өсч инфляцийн 0.65%-ийг бүрдүүлэв.
- Хувцас (0.57%) болон амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний (0.63%) бүлгийн үнэ өссөн нь улсын инфляци өмнөх сараас нэмэгдэхэд нөлөөлжээ.

2018 оны 2 дугаар улиралд



- Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 18.0%,
- Хадгаламжийн үлдэгдэл 11.8 их наяд төгрөг,
- Эдийн засгийн өсөлт 6.3%

2019 оны 2 дугаар улиралд



- Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.0%,
- Хадгаламжийн үлдэгдэл 13.9 их наяд төгрөг,
- Эдийн засгийн өсөлт 8.6%

2 "БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР"-ИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭВ



"Банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд 2019 онд УИХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байгаа дараах хуулийн төслүүдийг боловсруулж, хууль санаачлагчдад уламжиллаа. Тухайлбал, Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл болон Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг уламжлав. Мөн чанаргүй активыг бууруулах ажлын хүрээнд Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл зэрэгт нэмэлт өөрчлөлтийг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжлаад байна. Цаашид Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Векселийн тухай хуулийн төслийг хууль санаачлагчид уламжлахаар бэлтгэж байна.

“Банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд шинээр батлагдсан хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын дагуу холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулж, хуульд нийцүүлэн өөрчилснөөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүллээ. 2019 оны 1-р хагас жилийн байдлаар батлагдсан журмуудаас дурдвал:

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам;
- Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журам;
- Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам;
- Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам;
- Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан шийдвэрлэх заавар;
- Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам;
- Банкны чанаргүй активыг бууруулах удирдлага, тогтолцоо, тайлагнах үлгэрчилсэн журам;
- Дахин хөрөнгөжүүлсэн банкнаас гаргах хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийн журам;
- Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам зэрэг багтана.



3 МОНГОЛБАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ 1.2 ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР ӨСЧ, АУДИТААР БАТАЛГААЖИВ

Монголбанкнаас сүүлийн хугацаанд хуримтлагдсан алдагдлаа бууруулах чиглэлээр өргөн хүрээнд ажилласны үр дүнд өөрийн хөрөнгө -3 их наяд төгрөг байсныг 2017 онд 200 тэрбум төгрөг, 2018 онд 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүллээ. Монголбанкнаас Эрдэнэсийн санд хадгалагдаж буй түүхийн хосгүй үнэт эд зүйлс болон бусад үзмэрт анх удаа олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэсний үр дүнд Төв банкны өөрийн хөрөнгө -1.8 их наяд төгрөг болж буурсан санхүүгийн тайланг Прайсуотер-Хаус Куперс аудитын компанийн хийсэн хөндлөнгийн аудитаар баталгаажуулав. Өнөөгийн баримталж буй зарчим, үйл ажиллагааг цаашид хадгалан ажиллавал Монголбанк 2019 болон 2020 онд үргэлжлүүлэн ашигтай ажиллах бөгөөд цаашид Төв банкны өөрийн хөрөнгийг эерэг болгох зорилт тавин ажиллаж байна.


109
1224 20 OZS
FINE
999
DAL.

4 ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ 4.0 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЧ ӨСЛӨӨ



ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ
(ТЭРБУМ АМ.ДОЛЛАР)



Монгол Улсын гадаад валютын албан нөөц (ГВАН) тогтвортойгоор өссөөр 2018 оны 6-р сарын байдлаар 4.0 тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь сүүлийн 6 жилийн дээд үзүүлэлт юм. ГВАН-ийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь Монголбанкнаас худалдан авах үнэт металлын хэмжээ нэмэгдсэн явдал байв. Монголбанк 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авч, энэ эх үүсвэрээс жил бүр 700-800 сая ам.доллараар Монгол Улсын ГВАН-ийг нэмэгдүүллээ. Түүнчлэн томоохон экспортлогч компаниудтай хэлцэл хийх замаар гадаад валютыг худалдан авч, гадаад валютын нөөцийг арвижуулав.

Уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт хэвийн үргэлжилсэн, экспортын гол түүхий эдийн үнэ, эрэлт тогтвортой байсан, ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” амжилттай хэрэгжиж байгаа, банк, санхүүгийн байгууллагууд олон улсын санхүүгийн зах зээлээс хөнгөлөлттэй эх үүсвэр татсан зэрэг нь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд гол түлхэц боллоо.

5 ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ ҮР ДҮНД ХҮРЧ ЭХЛЭВ

"Зээлийн хүүг буруулах стратеги" болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг цогц баримт бичгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2018 онд баталсан. Монголбанкнаас тус стратегийг хэрэгжүүлэх хүрээнд эдийн засгийн эрсдэлийг бууруулах, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх, макро зохистой бодлого хэрэгжүүлэх зэрэг чиглэлээр олон ажил хэрэгжүүлсний үр дүнд шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2019 оны 6-р сард 17.0%-д хүрч, 2017 оны 8 сартай харьцуулахад 3.2 хувиар буурлаа.

СТРАТЕГИ ЗОРИЛГО ЗОРИЛТУУД

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ОРЧИН

- Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах
- Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын секторын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах.
- Төсвийн сахилгыг хангах, макро бодлогын уялдааг сайжруулах.
- Эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХҮҮНИЙ ШИЛЖИХ НӨЛӨӨ

- Бодлогын хүүний коридорыг ашиглан хүүний нөлөөг сайжруулах.
- Санхүүгийн долларжилтыг бууруулах.
- Хүчтэй санхүүгийн системтэй болох, ХЗЗ-ийн хөгжлийг эрчимжүүлэх.

БАНКУУДЫН ҮР АШИГТ УДИРДЛАГА

- Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх.
- Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох
- Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх.
- Төрийн болон санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

6 МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН "ШИЛДЭГ ТҮНШЛЭЛ–2019" ШАГНАЛ ХҮРТЛЭЭ

Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллагын дээд хэмжээний жил бүр болдог чуулга уулзалт энэ жил Өмнөд Африкийн Бүгд найрамдах улсын Йоханнесбург хотноо боллоо. Тус уулзалтын нэг чухал ач холбогдол бүхий хэсэг бол "Дэлхий нийтийн санхүүгийн хүртээмж-2019" шагнал гардуулах ёслолын арга хэмжээ юм. Ийнхүү 2019 оны 6-р сарын 19-ний өдөр Дэлхий нийтийн санхүүгийн хүртээмж-2019" шагнал гардуулах ёслол 8 дахь удаагаа болж, шилдгийн шилдгийг тодруулсан ба Монгол Улсад "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлснийг үнэлж "Шилдэг түншлэл-2019" төрөлд шагнал олгов.

Энэхүү шагналыг иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих чиглэлээр дараах үр дүнд хүрч, хамтран ажилласан тул олгов. Үүнд:

- Хөтөлбөрийн үндсэн 4 чиглэлд ихээхэн ахиц гаргаж, санхүүгийн хүртээмж нэмэгдэв;
- 19 аймагт нийт 560 сургагч багш, МСҮТ-ийн 98 багш, 21 арга зүйч нарыг бэлтгэн, орон нутгийн иргэдэд бодитоор хүрч чадах дэд бүтцийг бүрдүүлэв;
- ЕБС-ийн ахлах ангид "Бизнес судлал" хичээл, Их дээд Сургуулиудад "Хувь хүний санхүү" хичээл ордог болов;
- Дэлхийн мөнгөний долоо хоногийг 3-р сард тэмдэглэж, үндэсний хэмжээнд санхүүгийн боловсрол түгээх сургалт, уулзалтыг 628 удаа хийж 21400 гаруй хүүхэд болон насанд хүрэгчдэд хүргэв;
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 16 гарын авлага, сургагч багшийн ном, комик ном зэргийг боловсруулж өргөн хүрээнд түгээв;
- Дэлхийн банк, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь Сан зэрэг олон улсын болон Монгол Улсын төрийн, төрийн бус байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллаж Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын INFE-ийн гишүүн болсон зэрэг олон амжилтын үр дүнд тус шагналыг хүртлээ.

Энэ удаад нийт 170 улс өрсөлдсөн бөгөөд Шилдэг улс категорийн "Шилдэг түншлэл" төрөлд Монгол Улс нь Ангола, Аргентин, Колумби, Марокко, Португали улстай тунаж үлдсэнээр эцсийн шатанд тэргүүлэв.

GLOBAL MONEY WEEK

Child & Youth Finance International
FSCA
FMT

GLOBAL MONEY WEEK

7 ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ТОМООХОН АХИЦ ГАРЛАА

БАНК СҮЛЖЭЭ

card

Монголбанк Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Төлбөрийн системийн шинэчлэл төслийн (ТСШТ)-ийн хүрээнд хэд хэдэн ажлыг 2019 онд хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, ТСШТөслийн хүрээнд Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-ийг бэхжүүлэх, банк дундын төлбөрийн системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор ҮЦГТ-ийн барилгыг олон улсын стандартын шаардлага хангасан, орчин үеийн дата төвийн барилгын жишигт нийцүүлэн бариулж эхэллээ. Уг барилгыг 2020 оны эхний хагас жилд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

ТСШТөслийн хүрээнд дата төвүүдийг шинэчлэх, нууцлал аюулгүй байдлын төвийг байгуулах зэрэг төслийг үе шаттай хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн Дархан-Уул аймагт байрлах нөөц дата төвийг шинэчлэх ажлыг 2019 оны 3-р сард дуусгаж хүлээн авав. Мөн ҮЦГТ-ийн шинэ байранд байрлах орчин үеийн дата төвийн дэд бүтэц, олон улсын стандарт шаардлага (TIER II)-ыг хангах төвшний Дата төв байгуулах нээлттэй тендерийг зохион байгууллаа.

Цаашлаад Төв банкны суурь бүртгэлийн болон ERP системийг нийлүүлж, суурилуулах ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг зарласнаар, “Intellect Design Arena” компани эцсийн шатанд шалгарлаа. Тус компанитай 2019 оны 6-р сарын 21–ний өдөр хамтын ажиллагааны гэрээг байгуулав. Энэхүү төсөл нь олон улсын төв банкнуудад хэрэгжиж буй “Intellect Quantum Central Banking” цогц шийдлийг нэвтрүүлэх аж. Энэ нь суурь бүртгэлийн ерөнхий дэвтэр, банкны үйлчилгээ, төрийн үйлчилгээ, мөнгөний бодлого, валютын ханшийн удирдлага, гадаад худалдаа, интернет банкны үйлчилгээ, нөөцийн удирдлага, төсвийн удирдлага гэх мэт хоорондоо нягт уялдаа бүхий удирдлагын олон модулиудыг агуулна. “Intellect’s Quantum Central Banking” шийдлийг Швед, Армен, Индонез, Этиоп, Энэтхэг зэрэг олон улсын төв банкууд ашиглаж байна.

VING DIGITAL
DERSHIP
ING S M / BoM GENERAL LEDGER
ing C y, 21st June, 2019

БАГА ДҮНТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ
АСН+ СИСТЕМИЙГ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН
ЭХЭЛЛИЙН ЁСЛОЛ
PROJECT COMMENCEMENT CEREMONY
OF AUTOMATED CLEARING HOUSE (ACH+) SYSTEM

8 МОНГОЛБАНК УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монголбанк 2018 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулж, сүүлийн гурван жилд улс орны эдийн засгийг сэргээх, улсын өрийн дефолтоос зайлсхийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг сэргээх, банк санхүүгийн салбарыг эрүүл, чийрэг болгох, Монголбанкыг орчин үеийн төв банкны жишигт хүргэн чадавхжуулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж буй талаар мэдээлэл хийлээ. Эдгээр бодлогын үр дүнд банк санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийг эхлүүлж, банк санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг сайжруулсан, ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т хамрагдаж үүрэг амлалтаа амжилттай хэрэгжүүлэн эдийн засгийн сэргэлтэд бодит хувь нэмэр оруулсан, дотоод үйл ажиллагаандаа шинэчлэлт хийж, орчин үеийн төв банкны жишигт хүргэхээр ажиллаж байгаа зэрэг 5 бүлэг бүхий үйл ажиллагааг танилцууллаа.

Мөн Монголбанкнаас орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хөтөлбөрийг тэргүүлэн хэрэгжүүлж байгаа. Үүний хүрээнд 2019 оны эхний 6 сарын байдлаар нийт 210 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2,937 иргэнд олгоод байна.

Цаашид Монгол Улс 2020-2024 оны хооронд төр болон хувийн хэвшлийн томоохон дүнтэй гадаад өр, төлбөрийг төлж барагдуулах, манай улсын экспортын гол түүхий эдийн үнэ 2021 оноос буурах, ФАТФ-ын саарал жагсаалт орох сорилтууд байгааг дурдаж, авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжийг хүргүүлэхээр боллоо.

I.Төв банкуудын товч түүх
Засгийн газраас хараат, Улсын өмчит төв банкууд
Макро бодлого
Санхүүгийн үйлчилгээ

9 ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУУЛГАНЫГ "САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ" СЭДВИЙН ДОР АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголбанкнаас 2018 онд Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулганыг зохион байгуулж байсан бөгөөд энэ жил "Эдийн засгийн бодлогын чуулган 2019"-г Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралтай хамтатган "Санхүүгийн салбарын хөгжил: Өнгөрсөн, Одоо, Ирээдүй" ерөнхий сэдвийн хүрээнд 4-р сарын 19-ний өдөр зохион байгууллаа. Энэ удаагийн чуулганаар "Банкны хөгжил-95 жил", "Санхүүгийн салбарын дархлааг бэхжүүлэх нь", "Финтек: Санхүүгийн зах зээлийн ирээдүй" гэсэн 3 сэдвийн хүрээнд илтгэл танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Чуулганд УИХ, Монголбанк, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Үндэсний хөгжлийн газар, Хөгжлийн банк, арилжааны банкууд болон Олон Улсын байгууллагуудын төлөөлөөс бүрдсэн 100 гаруй төлөөлөл оролцлоо.

10 ОУВС-ИЙН АЖЛЫН ХЭСЭГ ДҮРМИЙН IV ЗААЛТЫН 2019 ОНЫ ЗӨВЛӨЛДӨХ ЯРИА ХЭЛЭЛЦЭЭГ ХИЙЛЭЭ

ОУВС-ийн ажлын хэсэг 2019 оны 6-р сарын 19-өөс 28-нд Монгол Улсад ажиллаж, ОУВС-ийн Дүрмийн IV заалтын дагуу хэрэгждэг 2019 оны зөвлөлдөх яриа хэлэлцээг хийлээ. Улс орнууд ОУВС-ийн гишүүн болсноор тус сангийн дүрмийг зөвшөөрч, дүрмийн IV дэх заалтын дагуу тогтсон хугацаанд эдийн засаг, санхүүгийн секторын тогтвортой байдлаа үнэлүүлэх, зөвлөлдөх хэлэлцээг хийдэг билээ. Энэ удаа ажлын хэсэг УИХ-ын дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Засгийн газрын бусад албан тушаалтан, хувийн хэвшил, санхүүгийн салбарын төлөөлөлтэй уулзав.

Тус зөвлөлдөх хэлэлцээний төгсгөлд ОУВС-ийн ажлын хэсгийн ахлагч Жэф Готтлийб 2016 онтой харьцуулбал Монгол Улсын эдийн засагт мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гарсныг дурьдаад гадаад секторын хувьд Монголбанк нөхцөл байдлыг ашиглан гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлж чадсаныг онцоллоо. Цаашид эдийн засгийн хамгаалалтыг бий болгож, шокоос сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж, бүтцийн өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх замаар өнөөг хүртэл хүрсэн үр дүнг өргөжүүлэх нь тэргүүлэх зорилт байх ёстойг ажлын хэсэг тэмдэглэв.

Mongol Bank
МОНГОЛБАНК

11 МОНГОЛ УЛСАД БАНК САНХҮҮГИЙН САЛБАР ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ 95 ЖИЛИЙН ОЙГ ӨРГӨН ХҮРЭЭНД ТЭМДЭГЛЭВ

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойг угтаж “Банкны хөгжил-95 жил” аяныг 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл зохион байгууллаа. Тус аян нь банкны салбарын түүхийг таниулах, төв банк болон арилжааны банк, харилцагч хоорондын итгэлцэл, банкны үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд зорьсон билээ. Ойг угтсан үйл ажиллагааны хүрээнд Монголбанк болон банк үүссэн түүхэн баримтуудыг эмхтгэн хойч үедээ үлдээх зорилгоор “Монгол Улсын эрдэнэсийн сан”, “Монголбанкны түүхийн альманах”, “Монголын эзэнт улсын зоос, мөнгөн тэмдэгт”, “Монгол Улсын төлбөрийн хэрэгсэл”, “Монгол Улсын гүйлгээний болон дурсгалын зоос” гурван цуврал түүхийн бүтээл, “Монгол банк 95: Түүх ба баримт”, “Монгол төрийн эдийн засгийн бодлого: сорилт, сургамж, асуудал 1911-2018” номыг тус тус хэвлүүлж, Хөгжилд түүчээлсэн 95 жил баримтат нэвтрүүлэг, Монгол Улсын банкны салбарын хөгжлийн он цагийн товчоон хроник зэрэг бүтээлийг уншигчдад толилуулав.

Аяны хүрээнд Банкны хөгжил-95 жил үзэсгэлэн гаргаж, Монголчуудын эртнээс эдүгээг хүртэлх хэрэглэж ирсэн төлбөрийн хэрэгслүүд, дурсгалын зоос, үнэт цааснууд, банкинд хэрэглэж ирсэн машин техник зэргийг үзүүлсэн нь иргэдийн талархлыг хүлээж, үзэсгэлэн гаргасан 20 хоногт 2900 хүн үзэж сонирхжээ. Банкны салбарын нийт 16 мянган ажилтан “Сайн үйлсийн аян” өрнүүлж, Уран зургийн галерейд хагас зуун жилийн хугацаанд хадгалагдаж буй Монголын дүрслэх урлагийн үнэт өв болсон бүтээлүүдийг сэргээн засварлахад хандив өргөснөөр алдарт зураач Л.Гаваа гуайн “Алтайн уулс” уран зураг дахин үзэгчдийн өмнө дэлгэгдэх боломжийг бүрдүүлэв.

Монголбанкны ажилтнуудын сайн санааны хандивын хөрөнгөөр Монгол Улсын консерваторын сургалтад зориулж АНУ-ын "Kimball" брэндийн төгөлдөр хуур болон Герман, Солонгос улсын хамтарсан "Samick" брэндийн төгөлдөр хуурыг бэлэглэллээ. Түүнчлэн нийгмийн хариуцлагын хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд банкны салбарын нийт ажилтан мод тарив. Спортын арга хэмжээг өргөн хүрээнд хийж, марафон гүйлт, сагсан бөмбөг, шатрын тэмцээнийг банкны салбарын хэмжээнд амжилттай зохион байгуулав. Харилцагчдад банкны үйл ажиллагааг танин мэдүүлэх, тэдний санхүү эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтуудыг амжилттай зохион байгуулаа. Ногоон эдийн засгийн төлөө, эко банк байх үйлсэд нэгдэж Тогтвортой санхүүжилт хөтөлбөрт хамрагдаад байна. Түүхт 95 жилийн ойн баярын арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж, Сүхбаатарын талбайд Банкны өдөрлөгийг харилцагчдын хамт тэмдэглэлээ. Нийт банкир, Төв банкны үе үеийн удирдлагууд, ахмад ажилтнуудаа хүндэтгэн урьсан ойн баярын хурлыг Соёлын төв өргөөнд зохион байгуулж, Монгол Улсын Консерваторын оюутан сурагчид урлагийн тоглолт толилууллаа.

12 "ЭХ ОРНЫХОО АЛТЫГ ЭРДЭНЭСИЙН САНДАА" АЯНЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ

"Алт-2" үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа" аяныг хагас жилийн хугацаатай хэрэгжүүлж эхэллээ. Аяны хүрээнд алт олборлогч аж ахуйн нэгж, бичил уурхайчидтай уулзалт сургалт хийх, тэдэнд тулгарч буй бэрхшээл хүндрэлийг судлах, арилжааны банкуудад алтны худалдан авалтыг нэмэгдүүлэхэд харилцагчдадаа мэдээлэл өгөх гарын авлагаар хангах зэрэг олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх байдлаар Монголбанк аж ахуйн нэгж, иргэдээс нийт 6.0 тонн үнэт металл худалдан авч, гадаад валютын улсын нөөцийг 209 сая ам.долларaар нэмэгдүүллээ. Орон нутагт алт худалдан авах үйл ажиллагааг ойртуулснаар 2019 онд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэст 126 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбарт 221 кг үнэт металлыг худалдан аваад байна.


Монголбанкны худалдаж авсан алтны хэмжээ /тонн/
Дэлхийн зах зээл дэх алтны дундаж үнэ (ам.доллар/трой унци, баруун тэнхлэг)
25,0
20,0
15,0
10,0
5,0
-
1800
1600
1400
1200
1000
800
600
400
200
0
1,0 0,8 0,9 1,2 2,0 4,5 6,0 8,9 8,1 10,9 12,3 13,8 12,1 11,1 11,6 15,2 9,0 8,4 8,2 5,0 2,1 3,3 3,3 6,0 12,7 15,1 18,3 20,0 21,9 6,0
1990 1991 1992 1993 1994 1995 1996 1997 1998 1999 2000 2001 2002 2003 2004 2005 2006 2007 2008 2009 2010 2011 2012 2013 2014 2015 2016 2017 2018 19.06.26

Монголбанкны алт худалдан авах үнэ (төгрөг/грамм)
124 000,00
122 000,00
120 000,00
118 000,00
116 000,00
114 000,00
112 000,00
110 000,00
108 000,00
106 000,00
104 000,00
19.06.03 19.06.04 19.06.05 19.06.06 19.06.07 19.06.08 19.06.09 19.06.10 19.06.11 19.06.12 19.06.13 19.06.14 19.06.15 19.06.16 19.06.17 19.06.18 19.06.19 19.06.20 19.06.21 19.06.22 19.06.23 19.06.24 19.06.25 19.06.26 19.06.27

13 "ХАРИУЦЛАГАТАЙ ХАРИЛЦАГЧ – ХАРИУЦЛАГАТАЙ БАНК" АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачилгаар "Хариуцлагатай харилцагч – Хариуцлагатай банк" аяныг Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо болон холбогдох бусад байгууллага хамтран 2019 оныг дуустал хэрэгжүүлж эхэллээ. Аяны нээлт 6-р сарын 12-ны өдөр болсон бөгөөд цаашид харилцагчдад чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Банкны санхүүгийн чадавхийг илэрхийлдэг үзүүлэлтүүдийг иргэдэд ойлгомжтой мэдээлж, тайлбарлах,
- Санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг зохистой сонгоход дэмжлэг үзүүлэх, мэдээлэл сургалт зохион байгуулах,
- Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар бүрэн мэдээлэл өгөх,
- Банкны үйл ажиллагааны талаарх цогц ойлголтыг олгох зэрэг болно.

Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад санхүүгийн хэрэглэгчийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн салбарын шударга өрсөлдөөнийг бэхжүүлэх нь чухал үүрэгтэй. Үүний тулд "Хариуцлагатай харилцагч – Хариуцлагатай банк" аяныг хэрэгжүүлснээр иргэд, олон нийтэд банкны үйл ажиллагааны талаар цогц мэдээлэл олгох юм.

MBA
"ХАРИУЦЛАГАТАЙ ХАРИЛЦАГ
ХАРИУЦЛАГАТАЙ БАНК"

14 МӨНГӨН ДЭВСГЭРТИЙН ХАМГААЛАЛТЫН ЭЛЕМЕНТҮҮДИЙГ САЙЖРУУЛЖ, НӨӨЦ ДАХИН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Үндэсний мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэж байгаагаас хамгаалах, сэргийлэх үүднээс Монголбанк нь мөнгөн дэвсгэртийн хамгаалалтын элементүүдийг сүүлийн үеийн шинэ дэвшилтэт технологи бүхий элементээр солих, сайжруулах, зарим нэг зураг, дүрсийг залруулахад анхааран ажиллаж байна.

Энэ хүрээнд эхний ээлжинд нөөцийг нь дахин бүрдүүлэх шаардлагатай байсан 5000 төгрөгийн дэвсгэрт дээр сүүлийн үеийн дэвшилтэт технологиор бүтээгдсэн 3 хэмжээст хөдөлгөөнтэй, Спарк бэхэн элемент оруулж, 2019 оны 1 дүгээр улиралд гүйлгээнд гаргаад байна.

Мөн энэ онд нөөцийг нь дахин бүрдүүлэх шаардлагатай байгаа 1-т, 50-т, 20000-тын дэвсгэртийн хамгаалалтын элементийг сайжруулахаар ажиллаж, дараах шинэлэг өөрчлөлтүүдийг хийхээр тогтлоо.





Үүнд:

- 1 төгрөгийн дэвсгэртийн хувьд усан хээ, соронзон чанартай утас нэмж оруулж өгснөөс гадна “Соёмбо”-ны галын дөл цэцэг шиг хэлбэртэй байсныг засав.
- 50 төгрөгийн дэвсгэртийн хувьд 3 хэмжээст хөдөлгөөнтэй, спарк бэхэн элементийг нэмж, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан элементийг цоо шинээр оруулж өглөө. Түүнчлэн дэвсгэртийн ар талд үзэгдэх таллаж гарсан адууг хасч, “Соёмбо”-ны галын дөлийг засаж сайжруулав.
- 20000 төгрөгийн дэвсгэртийн хувьд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий хамгаалалтын элементүүдтэй болгосон.

  Тухайлбал, дэвсгэртийн нүүрэн талд:

  - 4 морьтон баатрын дүрсийг загвар сайтай 3 хэмжээст хөдөлгөөнтэй, дээш, доош налуу хөдөлгөхөд өнгө нь солонгорон харагдах спарк элементтэй болгов.
  - 8мм-ийн өргөнтэй бичил хөдөлгөөнт туузан элементийг шинэчлэв.
  - харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгайлсан элемент нэмэв.

  Дэвсгэртийн ар талд:

  - Солонгорч харагдах судал бүхий элементүүдийг шинээр оруулав.

Дээрх сайжруулсан мөнгөн тэмдэгтүүдийг хэвлүүлэх ажлыг шат дараалан гүйцэтгэж байна.

15 БАНКУУДЫН ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРИЙГ МАГАДЛАН ШАЛГАХААР БОЛОВ



ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Монгол Улс банкны салбартаа активын чанарын иж бүрэн үнэлгээг хийсэн. Манай улс уг үнэлгээг Ази тивд Европын төв банкны стандартаар хийсэн анхны улс болов. Үнэлгээний үр дүнд өөрийн хөрөнгийг 2018 оны 12-р сард багтаан нэмэгдүүлсэн байх шаардлагыг 1-ээс бусад банкууд биелүүллээ.

Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай хуулийн дагуу "Капитал банк" ХХК-д зохих арга хэмжээг авсан хэдий ч биелэлт хангагдахгүй, улмаар хадгаламж эзэмшигч, харилцагч болон мөнгөн төлбөрийн шаардах эрх бүхий этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй, банк хоорондын төлбөр тооцооны гүйлгээг саатуулж болзошгүй нөхцөл байдал үүссэн тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкийг албадан татан буулгах шийдвэр гаргаж, банкны эрх хүлээн авагч томилов.

Монголбанк богино хугацаанд банкны эрх хүлээн авах үйл ажиллагааг хэрэгжүүлж, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран олон нийтэд мэдээлэл түгээлээ. Капитал банк нь банкны системийн 1.1 хувийг бүрдүүлдэг байсан бөгөөд системийн нөлөө бүхий банк биш тул эдийн засаг дахь санхүүгийн зуучлалд сөрөг нөлөө үзүүлээгүй. Монголбанк үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг ханган ажиллаж байна.

ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрийг тодруулах, магадлан шалгахаар тогтоод байна. Банкууд өөрийн хөрөнгөө зохистой эх үүсвэрээр нэмэгдүүлсэн байх нь зүй ёсны асуудал бөгөөд магадлан шалгах ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, харилцагчийн мэдээллийг нууцлах олон улсын стандартын дагуу хийхээр ажиллаж, сонгон шалгаруулалтыг явуулсан болно.

16 МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ЭДИЙН ЗАСАГ, БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭВ

Төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор 2018 оны 2-р улирлаас Мөнгөний бодлогын болон Банкны хяналт шалгалтын эрх бүхий шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн давуу эрхтэй саналаар гаргадаг байсныг өөрчлөн, хамтын удирдлагын зарчимд шилжүүлсэн. Энэ хугацаанд Монголбанкны Мөнгөний бодлого болон Хяналт шалгалтын хорооноос гарч байгаа шийдвэрүүд нь бүхэлдээ Монгол Улсад инфляцийн дарамтгүй эдийн засгийн өсөлтийг бүрдүүлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэлээ.

Тухайлбал, Макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг тэтгэврийн зээлд 70%, тэтгэврээс бусад хэрэглээний зээлд 60%-д тогтоон мөрдүүлэх, хугацааг 30 сараас хэтрэхгүй байлгах, ААН-ийн валютын зээлийн эрсдэлийн жинг 150% болгон нэмэгдүүлэх шийдвэрүүд гарснаар бизнесийн зээл нэмэгдэж, зээлийн долларжилт буурч эхэллээ. Мөн Төв банк болон банкны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт орсноор банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах журмууд шинэчлэгдэж, эрсдэлд суурилсан тогтолцоонд шилжих эхлэл тавигдав.

ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ ХУУЛЬ

27[3] дугаар зүйл. Мөнгөний бодлогын хороо

1. Мөнгөний бодлогын хороо долоон гишүүнтэй байх бөгөөд Монголбанкны ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас зургаан жилийн хугацаатай томилсон орон тооны бус дөрвөн гишүүнээс бүрдэнэ.

27[4] дүгээр зүйл. Банкны хяналт шалгалтын хороо

1. Банкны хяналт шалгалтын хороо нь банкинд хяналт тавих Монголбанкны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргана.

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ШИЙДВЭРҮҮД

2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 01-ЭЭС ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ШИЙДВЭРҮҮД

01 Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа дээд хязгаарыг 70 хувиар тогтоон мөрдүүлэх

02 Хэрэглээний зээлийн хугацааг 30 сараас хэтрүүлэхгүй байхаар тогтоох

03 ААН-д олгосон валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгон нэмэгдүүлэх

17 МОНГОЛ УЛС МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ

FATF-ын Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан бүлэг /APG/-ийн жилийн уулзалт 2018 оны 7-р сард болж, энэ үеэр Монгол Улс холбогдох хууль тогтоомжоо шинэчилсэн болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг харгалзан үзэж Монгол Улсын Өргөтгөсөн /эрчимжүүлсэн/ хяналтад байх хугацааг 2019 оны 10 дугаар сар хүртэл дахин сунгасан. Өнөөгийн байдлаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулж, дагалдах хуулиудад өөрчлөлт оруулсан, банк санхүүгийн холбогдох журмуудыг шинээр болон шинэчлэн баталсан, Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журмыг баталсан, Үндэсний зөвлөл болох Хамтын ажиллагааны зөвлөл байгуулагдаж тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа зэрэг ахиц гараад байна. Эдгээр болон бусад олон ажил хийсний үр дүнд 14 зөвлөмжийн үнэлгээг урьдчилсан байдлаар ахиулаад байна.

FATF

APG

Asia/Pacific Group
on Money Laundering

18 ГАДААД ХАРИЛЦАА, ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ ТОМООХОН АЛХМУУДЫГ ХИЙЛЭЭ

Олон улсын төв банкны жишигт хүрэх, дэлхий нийтээр хэрэгжүүлж буй бодлогын шинэ сорилт, түүнийг судлах, төлбөрийн системийн шинэ техник технологийг нэвтрүүлэхэд анхаарч гадаад хамтын ажиллагааныхаа цар хүрээг тэлж, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэв. Энэ хүрээнд Монгол Улс, ОХУ-ын банкуудын хамтарсан дугуй ширээний уулзалтыг зохион байгуулж, Хятад, Монголын дипломат харилцаа тогтсоны 70 жилийн ойг тохиолдуулан Хятадын Ардын банктай дээд хэмжээний дугуй ширээний уулзалт зохион байгуулахаар ажиллаж байна.

Мөн 2019 он гарсаар Олон улсын байгууллагуудын Монгол Улсыг хариуцсан зарим гүйцэтгэх захирал, суурин төлөөлөгч өөрчлөгдсөн бөгөөд үүний дагуу хамтын ажиллагааг бэхжүүлэх уулзалтуудыг хийлээ. Тухайлбал, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Дэлхийн Банкны Хятад, Монгол, Солонгос улсуудыг хариуцсан шинэ захирал Мартин Рейзерийг 4-р сард хүлээж авч уулзсан бол хамгийн сүүлд 6-р сард ОУВС-гийн захирлуудын зөвлөлд Монгол Улсыг төлөөлөн ажиллаж буй гүйцэтгэх захирал Найжел Рэйг, Азийн хөгжлийн банкны захирлуудын зөвлөлийн гишүүд буюу 55 улс хариуцсан 8 Гүйцэтгэх захирлыг хүлээн авч уулзлаа.







МОНГОЛБАНК

19 МОНГОЛБАНК ОУВС-ГААС БОЛОВСРУУЛАН ГАРГАСАН СТАТИСТИКИЙН "МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТЫН ТУСГАЙ СТАНДАРТ"-ЫГ НЭВТРҮҮЛЭВ

Улс орнуудын статистик мэдээллээ боловсруулан түгээж буй байдал болон статистикийн онцлог чанараас хамааран ОУВС нь улс орнуудыг статистик тархаалтын өөр өөр ангилалд хамааруулдаг. Монгол Улс 2000 оноос эхлэн ОУВС-гийн "Мэдээлэл тархаах ерөнхий систем"-ийн дагуу статистик мэдээллээ гаргаж, 2017 онд "сайжруулсан-мэдээлэл тархаалтын ерөнхий систем" /e-GDDS/-д, 2019 оны 4 дүгээр сард "Мэдээлэл тархаалтын тусгай стандарт"-д шилжсэн. "Мэдээлэл тархаалтын тусгай стандарт" нь статистик мэдээллээ стандартчилагдсан тодорхойлолт, давтамж, хэлбэрийн дагуу олон нийтэд зайлшгүй зарлах шаардлагыг тавьдаг статистик мэдээлэл тархаах дэлхийн жишиг стандарт юм. Уг стандартад шилжсэнээр статистикийн чанар сайжирч, тухайн улсын статистик мэдээлэлд итгэх итгэл нэмэгдэх, ил тод байдал сайжрах, олон улс дахь улсын нэр хүндэд эергээр нөлөөлөх, бусад улсуудтай харьцуулсан судалгаа шинжилгээ хийх боломжийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээний ажилд эерэг нөлөө үзүүлэх зэрэг давуу талыг бий болгодог.

Мөн "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл", Монголбанк мөнгө, санхүүгийн болон гадаад секторын статистик мэдээллийг "Мэдээлэл тархаалтын тусгай стандарт" –ын дагуу олон нийтэд түгээх бэлтгэл ажлыг хангах зорилт тавьж ажиллав. Монголбанк Монгол Улсын гадаад өр, гадаад валютын албан нөөцийн статистик мэдээллийг холбогдох стандартын дагуу 2019 оны 1 дүгээр улирлаас зарлаж эхлэв.

SDDS

stands for

Special Data Dissemination Standard

Монголбанкны

2016 он

11-р сарын 24-нд УИХ-аас "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг батлав.

11-р сарын 24-нд УИХ-аас "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийг батлав.

2017 он

5-р сарын 24-нд ОУВС-тай хэлэлцээрт хүрч "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж эхлэв.

Хуралдай бондын 600 сая ам.долларыг Засгийн газартай хамтран олон улсын зах зээл дээрээс амжилттай босгов.

Хятадын ардын банктай хийсэн 15 тэрбум юанийн своп хэлцлийн хугацааг 3 жилээр сунгав.

Гэрэгэ бондын 800 сая ам.долларыг 5.625%-ийн хүү, 5.5 жилийн нөхцөлтэй амжилттай босгов

Валютын захын дэд бүтцийг хөгжүүлэх банк хоорондын цахим талбарын арилжааг нэвтрүүлэв.

"Банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр"-ийг УИХ-аар батлуулж 10 орчим хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлж эхлэв.

Монголбанк "Дунд хугацааны хөтөлбөр"-ийг 5 үндсэн чиглэлд баталж, хэрэгжүүлэв.

Инфляцийн хүлээлтийн судалгааг Дэлхийн банкны "CAPI" системд суурилан хийдэг болов.

2017 оныг орон нутгийн хэлтэс, салбарыг бэхжүүлэх жил болгон зарласнаар 21 аймаг, 4 бүсийг хамарсан сургалт уулзалтууд хийв

Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх өргөн хэмжээний ажлууд хийж гүйцэтгэв.

Гадаад валютын албан нөөцийг 150% өсгөж 3 тэрбум ам.доллар хүргэв.

2018 он

2018 оныг банк санхүүгийн салбарын шинэчлэлийн жил болгон зарлаж, хууль эрх зүйн томоохон шинэчлэл хийгдэв.

Мөнгөний бодлогын шийдвэрийг хамтын удирдлага буюу хорооны зарчмаар гаргадаг болов

Онцлох үйл явдлын товчоон



Монголбанк юу хийдэг вэ?

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд зааснаар Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

- Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах
- Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
- Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдах, зохицуулах, хянах
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах
- Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалах
- Макро зохистой бодлого хэрэгжүүлэх

www.mongolbank.mn
Mongolbank.mn
@mongolbank_mn
Бага тойруу–3, 15160
Улаанбаатар–46, Монгол Улс